



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТУГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 1/28

Улаанбаатар хот

Өрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны
бодлого, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн дүрэм батлах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Налайхын Барилгын материал, үйлдвэрлэл технологийн паркийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны бодлогыг нэгдүгээр хавсралт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны бодлогыг нийт ажилтан, албан хаагчид болон паркийн нэгжээр элсэн орсон аж ахуйн нэгжүүдэд танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн /О.Уламбаяр/, Маркетинг, олон нийттэй харилцах харилцаа мэргэжилтэн /Э.Энгүүн/-д үүрэг болгосугай.

3. Бодлого, дүрэмд заасан заалтуудыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд өөрсдийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллахыг нийт алба хаагчдад даалгасугай.


ДАРГА



С.БАТЖАРГАЛ

000116

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨТҮГазрын даргын 2020
оны 07 сарын 20-ны өдрийн 18 тоот тушаалын
1 дүгээр хавсралт



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ДҮРЭМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“НБМУТП” ОНӨТҮГ (цаашид парк гэх)-н хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангах, дотоодын хяналт тавихад энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

- 1.1. Энэхүү дүрмийг паркийн нийт ажилтан, албан хаагчид болон паркийн нэгжүүд, бүх гэрээтүүд, үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа оюутнууд болон зочид өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.2. Энэхүү дүрэмд тусгагдаагүй үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого, ажлын байны эрүүл ахуйтай холбогдолтой асуудлыг Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын болон Олон улсын стандартууд, компанийн дотоод журмуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

**ХОЕР. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН (ХАБЭА) УДИРДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 2.1. Паркийн ХАБЭА-н удирдлага нь дараах зохион байгуулалт, бүтэцтэй байна.
Үүнд:
 - 2.1.1. Дарга
 - 2.1.2. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан
 - 2.1.3. ХАБЭА-н зөвлөл (орон тооны бус)
 - 2.1.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс (орон тооны бус)
 - 2.1.5. Аврах баг (орон тооны бус)
 - 2.1.6. Хэсэг нэгжийн удирдлагууд болон инженер техникийн ажилтнууд
 - 2.1.7. Нийт ажилтан, албан хаагчид, паркийн нэгжүүд, гэрээтүүд, дадлагын оюутнууд, ба зочид
- 2.2. Дарга нь паркийн ХАБЭА-н бодлогыг тодорхойлон баталж, бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай нөөцөөр ханган ажиллах бөгөөд ХАБЭА-н нийт

ажилтнуудыг өөрийн шууд удирдлага дор ажиллуулж, удирдлагын тогтолцооны хөгжлийг тогтмол хянана.

- 2.3. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь ХАБЭА-н менежментийн системийг бий болгон, байнга хөгжүүлэх бөгөөд ХАБЭА-н удирдлагын тогтолцоог мэргэжлийн зөвлөгөө, удирдлагаар тасралтгүй ханган ажиллана.
- 2.4. ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтныг даргын тушаалаар томилж, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлнэ.
- 2.5. ХАБЭА-н зөвлөл, түүний ажиллах журмыг даргын тушаалаар батална. ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан сургаж дадлагажуулна.
- 2.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс (комисс)-г даргын тушаалаар 3-5 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулна. Уг комисс нь Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-г үйл ажиллагаандаа мөрдлөг болгох бөгөөд гишүүдийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох зорилгоор журам баталж мөрдүүлнэ.
- 2.7. Аливаа болзошгүй гамшиг болон ослын үед хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгийг авран хамгаалах зорилгоор орон тооны бус “Аврах баг”-ийг бий болгон, сургаж, дадлагажуулан, бэлэн байдлыг хангуулж ажиллана.
- 2.8. Паркийн дарга, инженер техникийн ажилтнууд, нэгжийн удирдлага, хэлтэс, гэрээт байгууллагын нийт ахлах ажилтнууд өөрийн шууд удирдлага дор ажиллаж байгаа бүх ажилтан, албан хаагчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй.
- 2.9. Монгол улсын ХАБЭА-н тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь хэсэгт заасны дагуу “Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх” үүргийнхээ дагуу паркийн нийт ажилтан, албан хаагч, нэгж, гэрээтүүд, дадлагын оюутан ба зочид үүрэг хариуцлага хүлээн ажиллана.
- 2.10. ХАБЭА-н зөвлөл болон ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны өөрийн чиг үүрэгтэйгээ холбогдуулан тавьсан шаардлагыг нийт ажилтан, албан хаагчид, нэгжүүд болон гэрээт, туслан гүйцэтгэгчид, зочид шууд биелүүлэх үүрэгтэй.
- 2.11. Парк нь бүхий л үйл ажиллагааныхаа явцад хэрэгжүүлэх нийт төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг ХАБЭА-н арга хэмжээнд зарцуулна.

ГУРАВ. ХАБЭА-Н ҮНДСЭН ШААРДЛАГА

- 3.1 ХАБЭА-н үндсэн зарчим нь ажлын байр тус бүрийн аюулгүй ажиллагааны стандарт болон зааварчилгааг мөрдөж ажиллах замаар хэрэгжинэ.
- 3.2 Паркийн ХАБЭА-н бодлого нь ХАБЭА-н менежментийн системээр тодорхойлогдон хэрэгжинэ.
- 3.3 Парк нь үйл ажиллагааныхаа онцлогт тохирсон ХАБЭА-н менежментийн систем болон ажлын байрны эрсдлийн менежментийн тогтолцоог боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.4 Үйлдвэрлэлийн процесст бүх машин, механизм, тоног төхөөрөмж, даралтат сав, насос, шугам хоолой, цахилгаан болон өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийг

ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар, техник ашиглалтын заавартай байна.

- 3.5 Бүх машин механизм, цахилгаан тоноглол, даралтат сав, насос, шугам хоолой, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, тэмдэг тэмдэглэгээ, дохио санамж, зураг схем нь Монгол хэл дээр бичигдсэн байна.
- 3.6 Цахилгаан тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна.
- 3.7 Бүх цахилгаан тоног төхөөрөмж нь угсралтын зураг схемтэй, газардуулгатай, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.
- 3.8 Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд мэргэжлийн байгууллагаар техникийн магадлагаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авч, тэдгээрийн засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан болон эрх бүхий байгууллагын баталсан хугацаанд туршилт, тохируулга, баталгаажуулалтыг хийлгэсэн байна.
- 3.9 Даралтат сав, шугам хоолойд зохих шугамын дагуу туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгэж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах зөвшөөрөл авсан байна.
- 3.10 Даралтат сав, шугам хоолойг аюулгүй ажиллах, удаан хугацаагаар зогсоох болон хадгалах үеийн ашиглалтын журамтай байна.
- 3.11 Химийн хорт болон аюултай бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхит бодис түүний нөлөөллөөс ажилтнуудын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч байна.
- 3.12 Цахилгаан тоног төхөөрөмж, даралтат сав, насос, шугам хоолой, өргөх зөөх, тээвэрлэх механизм дээр болон хязгаарлагдмал, температурын өөрчлөлттэй орчинд ажиллах ажилтнууд нь ажилд гарахын өмнө эмчийн үзлэгт орсон байна.
- 3.13 Ажлын байрны дулаан, харьцангуй чийгшилт, гэрэлтүүлэг, дуу шуугиан нь стандартын шаардлагад тохирсон байх бөгөөд шаардлага хангахгүй байгаа нөхцөлд хүн нэг бүрийг зохих хувийн хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангасан байна.

ДӨРӨВ. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

- 4.1. Хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх шаардлагатай газар заавал өмсөж хэрэглэнэ.
- 4.2. Зөвхөн сургалтад хамрагдаж зохих зөвшөөрөл авсан ажилтнуудыг ажиллуулна.
- 4.3. Хориглосон газар тамхи татахыг хориглоно.
- 4.4. Ажил дээрээ мансуурсан буюу согтууруулах ундааны нөлөөнд байх, паркийн талбайд ямар нэгэн согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, худалдан борлуулах, биедээ авч явахыг хориглоно.
- 4.5. Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөнд ямар нэгэн аюул учруулж болзошгүй нөхцөл байдал гарсан тохиолдолд удирдах ажилтандаа мэдэгдэж байна. Та түүнийг засаж мэргэшсэн бол засаж залруулж болно.

- 4.6. Ажлын байранд тоглож наадахыг хориглоно.
- 4.7. Бүх ажилтан, албан хаагчид, нэгжүүд, гэрээтүүд паркаас баталсан дүрэм журам, Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөнө. Үүнд паркийн ашиглалтын талбайгаас гадуур хийгдэж байгаа ажлууд хамаарахгүй.
- 4.8. Хамгаалалтын хаалт хашлагуудыг анх тавьсан албан тушаалтнаас өөр хүн хөдөлгөх, байршлыг өөрчлөх, авахыг хориглоно.
- 4.9. Химийн хортой болон аултай бодистой харьцаж ажиллах, хадгалах, тээвэрлэх сургалтад ажилтнуудаа хамруулж, эдгээр бодисын ХАЛМ (хор аюулын лавлах мэдээлэл)-г бэлтгэн, бүх ажилтнуудад хэрэглэхэд бэлэн байлгана.
- 4.10. Хөдөлж байгаа машин механизм, тоног төхөөрөмжид суух, буух, орохыг хатуу хориглоно.

ТАВ. ПАРКЫН ДАРГА, ТӨСЛИЙН УДИРДЛАГА, НЭГЖ, ХЭЛТСИЙН УДИРДЛАГУУД, АХЛАХ АЖИЛТНУУДЫН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

- 5.1. Ажилтан бүрийн ажлын байрны тодорхойлолтод ХАБЭА-н үүрэг хариуцлагыг тодорхой тусгаж мөрдүүлнэ.
- 5.2. Ажлын байр тус бүрийн аюулгүй ажиллагааны журам, зааварчилгааг боловсруулан, зохих албан тушаалтнуудаар баталж мөрдүүлнэ.
- 5.3. ХАБЭА-н менежментийн системд өөрийн эрх, үүргийг ухамсарлан ойлгож, хэрэгжүүлнэ.
- 5.4. Ажлын байрны нөхцлийн болон эрсдлийн үнэлгээг байнга хийж байна.
- 5.5. Аюулыг олж илрүүлэх, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, аюулыг илрүүлж, устгах ажлын бүх шатанд байнгын хяналт тавьж ажиллана.
- 5.6. Өөрийн хариуцаж буй нэгжийн хүрээнд осол болон өмчийн эвдрэл гарах нөхцлийг бүрэн арилгах, ослын болон осолд дөхсөн тохиолдлын тайланг тухай бүр гаргаж, паркын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтанд өгч, шаардлагатай зөвлөгөө, зөвлөмж авч байна. Тухайн тохиолдлын эрсдлийн үнэлгээг гаргаж, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.
- 5.7. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нормд заасан хангалтыг байнга хийх бөгөөд ажилтнуудад тогтмол, зөв, бүрэн хэрэглэж сурах зан үйлийг хэвшүүлнэ.
- 5.8. Өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн тусгай зөвшөөрлийг авч, ажилтан, албан хаагчдыг хөтөлбөрийн тусгай сургалтад хамрагдаж, зохих дадлага, шалгалтад тэнцсэн тохиолдолд ажиллуулдаг зарчмыг хатуу баримтлан ажиллана.
- 5.9. Аюулгүй ажиллах "алтан дүрэм"-үүдийг бий болгож, мөрдлөг болгон ажиллана.

ЗУРГАА.АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНД

- 6.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтнуудыг бүрэн хамруулна.

- 6.2. Ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар, зан үйлд сургах, осол гэмтэл, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлсэн байна.
- 6.3. Нийт ажилтан, албан хаагч нар өөрийн эрүүл мэнддээ хяналт тавьж, оршин суугаа харьяаллын дагуу эмчийн хяналтад орж, өөрийгөө эрүүл байлгах, эрүүл мэндээ дэмжих боломжоор хангана.
- 6.4. Эмнэлгийн хугацаат ба урьдчилан сэргийлэх үзлэгийн байдалд дүгнэлт хийж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.5. Ажлын байрны нөхцөлд тохирсон хор саармагжуулах, дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр үнэ төлбөргүй хангах үүрэг хүлээнэ.

ДОЛОО.АЖИЛЛАХ ТААТАЙ НӨХЦӨЛ

- 7.1. Өөрийн ажилтнуудыг аятай, тохилог нөхцлийг бүрдүүлсэн ажлын байраар хангана.
- 7.2. Үйл ажиллагааны онцлогт нь тохирсон хувийн ариун цэврийг сахих боломжоор хангасан угаагуур, усанд орох байр, бие засах газартай байна.
- 7.3. Хооллох, ундлахад зориулсан байр, халуун хүйтэн усаар хангана.
- 7.4. Тааламжтай нөхцлийг бүрдүүлсэн тохижилттой, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээг байнга авна.

НАЙМ.БАЙГАЛЬ ОРЧИНД СӨРӨГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХГҮЙ БАЙХ

- 8.1. Парк, түүний нэгжүүд, тэдгээрийн удирдлагууд нь өөрийн ажил үйлчилгээ явуулж байгаа, үйлдвэрлэлийн талбай бүхий нутаг дэвсгэр, орчиндоо байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх үүрэг хүлээж, сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ авахыг бүрэн хариуцна.
- 8.2. Нэгж, түүний туслан гүйцэтгэгчид, гэрээтүүд нь байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулах тухай бүртээ паркийн удирдлагад мэдэгдэж, зохих зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлсний дараа ажлаа эхлүүлнэ.
- 8.3. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл бүхий ажил үүрэг гүйцэтгэж байхдаа, уг ажлыг дууссаны дараа талбайг паркийн захиргаанд хүлээлгэн өгнө. Аливаа хортой болон аюултай бодисын асгаралт, хөрс, ус, агаар, ургамал, амьтны аймагт хохирол учруулсан бол саармагжуулах, хохирол арилгах арга замыг хамгийн түрүүнд авч хэрэгжүүлнэ.
- 8.4. Бүх төрлийн тээврийн хэрэгсэл нь дуу шуугиан бага гаргах, шатах тослох материал асгахгүй байх, замгүй газраар зорчихгүй байх зарчмаар ажиллана.
- 8.5. Орон нутгийн иргэд, ан амьтны нутагшил, хөрс, ургамал, агаар, усыг бохирдуулахгүй, нутгийн үзэсгэлэнт байгаль, түүх дурсгалын хөндөхгүй хэвээр хадгална.
- 8.6. Аливаа ажил дуусмагц байгаль орчны нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийх үүргийг бүх нэгжүүд адил тэгш хүлээнэ.

ЕС.ДОТООД ХЯНАЛТ

9.1 ХАБЭА-н дотоод хяналтыг дараах байдлаар тогтмол хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Өдөр тутмын хяналтыг парк, түүний нэгжийн ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, хэсэг
- ✓ Сар тутмын хяналтыг паркийн ХАБЭА-н зөвлөл
- ✓ Ерөнхий хяналтыг паркийн болон нэгжийн удирдлагууд
- ✓ Стандарт хяналтыг Монгол улсын болон орон улсын эрх бүхий аудиторууд

АРАВ.ХҮЛЭЭХ ҮҮРЭГ.

- 10.1. Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль тогтоомжууд, дотоод дүрэм журмууд, стандартууд зөрчигдөж байна гэж үзвэл парк нь зохих хяналтын байгууллагад хандан дүгнэлт гаргуулах, шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
- 10.2. Паркийн ХАБЭА-н асуудал хариусан ажилтан нь нэгжүүдийн үйл ажиллагаанд гарч байгаа ХАБЭА-н асуудлаар зөвлөмж гаргах, шаардлага тавих, хяналтын байгууллагад хандаж асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг хүлээнэ.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк” ОНӨТҮГазрын даргын 2020
оны 07 сарын 30-ны өдрийн А/2 тоот тушаалын
2 дугаар хавсралт

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГАЗРЫН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, БАЙГАЛЬ
ОРЧНЫ БОДЛОГО

“Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, Технологийн парк” ОНӨТҮГ нь өөрийн ажилтан, албан хаагчид, паркийн нэгжүүд, гэрээтүүд ба хөршүүд болон орон нутгийн оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба байгаль орчныг сахин хамгаалах нь бизнес стратегийн салшгүй хэсэг мөн гэж итгэдэг. Парк нь дээр дурдсан талуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг судалгааны, бүтээн байгуулалтын, үйлдвэрлэлийн бүхий л шатуудад анхаарлын хамгийн өндөр түвшинд байлгана.

Парк, түүний ажилчин, албан хаагчид нь

- ЭМААБО-ны чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжуудыг бүхий л үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, Монгол Улсын болон Олон улсын норм, стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- Аливаа төслийн хүрээнд нийт ажиллагсадын эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлүүдийг тодорхойлж, арилгах буюу багасгах арга хэмжээ авна.
- Байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг үргэлж хянаж үнэлнэ.

Энэхүү зарчмуудыг дэмжих зорилгоор бид дараах арга хэмжээг авна:

- ✓ Бидний үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийг тодорхойлж хязгаарлана.
- ✓ Ажлын төлөвлөгөөтэй уялдуулж эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны хөтөлбөрийн боловсруулалт болон хэрэгжүүлэлтэд ажилчдын оролцоог хангана.
- ✓ Ажилчдыг аюулгүй арга барилаар хөдөлмөрлөж хэвшүүлэх зорилгоор эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны сургалтуудыг төлөвлөж, сургаж, дадлагажуулна.
- ✓ Осол гарч болзошгүй эрсдэл, онцгой байдлыг тодорхойлно. Олон нийт ба ажилтан, албан хаагч нараас санал асуулга явуулж, дүн шинжилгээг тогтмол хийнэ.
- ✓ Энэхүү бодлогын хүрээнд бүх ажилтан, албан хаагчид, нэгжүүд, гэрээт ба хамтран ажиллагч нарт эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар хүлээх үүрэг хариуцлагыг танилцуулж, тэдний алдаатай үйлдэлд нь зөвлөн тусалж, залруулга хийнэ.
- ✓ Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны талаар сайн ажилласан тохиолдол бүрийг сайшаан дэмжинэ.

- ✓ Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын менежмент ба гүйцэтгэлийг байнга сайжруулах зорилт тавина.
- ✓ Энэхүү бодлогыг олон нийтэд танилцуулан шаардлагатай нөөцөөр хангана.
- ✓ Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба байгаль орчны үр дүнтэй журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- ✓ Энэхүү бодлогын хэрэгжилтэд жил бүр дүн шинжилгээ хийнэ.